*ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2005 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн хурлын 10 дугаар тогтоолын хавсралт*

# ШУА-ИЙН ХАРЪЯА ХҮРЭЭЛЭН, ТӨВҮҮДЭЭС ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД СУРАЛЦАЖ БУЙ АСПИРАНТ, ДОКТОРАНТ НАРТ ЦАЛИН ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь Оросын Холбооны Улсад суралцагч аспирант, докторант нарын сард авч буй тэтгэмж нь тухайн орны амьжиргааны доод түвшингээс бага, амьжиргааны хэрэглээ болоод судалгаа, шинжилгээ явуулахад хүрэлцэхгүй байгааг харгалзан үзэж "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль, "Онолын суурь судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх журам"-ын холбогдох заалтыг үндэслэн суралцах албан ёсны хугацаанд нь урьд авч байсан үндсэн цалингийн 60 хувьтай тэнцэх хэмжээний цалин олгож байхад оршино.

## Хоёр. Тэтгэлэг олгох үндэслэл

1. Оросын Холбооны Улсад суралцагч аспирант, докторант нар нь ШУА-ийн хүрээлэн, төвүүд дээр хэрэгжүүлж буй суурь судалгааны сэдэв, ШУТ-ийн төсөлт ажлын хүрээнд судалгааны ажлаа явуулна.

2. Суралцагч нь манай орны, эсвэл Монгол улсад чухал ач холбогдолтой объектыг судлана.

3. Хүрээлэн, төвийн захирал нар цалинжиж буй докторант нартай жил бүр "Үр дүнгийн гэрээ" байгуулж ажиллана.

4. Суралцах хугацаандаа ШУА-ийн харъяа хүрээлэн, төвөөс цалинжиж буй докторант нар нь эрдмийн зэрэг хамгаалсны дараа тухайн хүрээлэнд ажиллана. Энэ нь хүрээлэнгийн захиралтай байгуулсан гэрээгээр зохицуулагдана.

## Гурав. Тэтгэлгийн баталгаажуулалт

1. Цалин олгох саналыг хүрээлэн, төвүүд эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар ирүүлнэ.

2. Цалин олгох тухай асуудлыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар баталгаажуулна.

---ooOoo---